

БАТЛАВ:

ЗАХИРАЛ

Т.АЗБАЯР



2019 оны 02 дугаар сарын 11-ны өдөр

Сайншанд хот

**ЧАНДМАНЬ-ИЛЧ ХХК-ИЙН АЖИЛТНУУДЫН ХӨДӨЛМӨР
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ЗОИУЛАЛТЫН ЗУНЫ ХУВЦАС
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

ТЕНДЕРИЙН НЭР: *Чандмань-Илч ХХК-ийн Чандмань-Илч ХХК-ийн ажилнуудын хөдөлмөр хамгааллын тусгай зориулалтын зуны хувцас нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер*

ТЕНДЕРИЙН ДУГААР: *ХАЧИ-2019/04*

ТӨСӨВТ ӨРТӨГ: *17,160,000*

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019 оны 02 дугаар сарын 15

Тендер шалгаруулалтын нэр: *Чандмань-Илч ХХК-ийн ажилнуудын хөдөлмөр хамгааллын тусгай зориулалтын зуны хувцас нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер*

Тендер шалгаруулалтын дугаар : ХАЧИ-2019\04

Төсөвт өртөг: 17,160,000

Тендерт оролцогч нь: тендерийн баримт бичгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрж цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 МБ, нэг файлын хэмжээ 15 МБ байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Дотоодын давуу эрх: тооцно.

Санхүүжилт: Урьдчилгаа 40% олгоно, барааг нийлүүлснээс хойш үлдэгдэлийг ажлын 10 хоногт онд багтаан олгоно.

Тендерийг **2019 оны 02-р сарын 22-ны өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцор хүсэлтэй тендерт оролцогчдыг **2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 30 минут**-т нээнэ.

Төлбөр хийх хэлбэр: Дансаар тушаана

Банкны нэр: ХААН банк

Дансны дугаар: 5360001473

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь, Сайншанд, 2-рбаг, Энхтайвны гудамж, Чандмань-Илч ХХК-ын удирлагын байр, 3-р давхар, 307 тоот

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |

**8. Гэрээ байгуулах
эрх олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [I] жилийн санхүүгийн тайлан</p> <p>Сүүлийн [I] жил, туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/</p> <p>Тендерт оролцогч нь тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрийн танилцуулга, 2. Үйл ажиллагаатай холбоотой чиглэлээр хууль, шүүхийн байгууллагаар шийдэгдээгүй хэрэг маргаангүй байх. 3. Түүхий эд материал чанарын шинжилгээний гэрчилгээ 4. Ажлын хувцасны материаланд хяналт шалгалт хийлгэсэн дүгнэлт 5. Үнийн саналтай хамт жишиг ажлын зуны тусгай хувцас /48 газмер/ ирүүлэх
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>[Дорноговь Сайншианд, 3-р баг, Энхтайвны гудамж Чандмань-Илч ХХК-ийн удирдлагын байр]</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>[3-р давхарт 307 тоот/</i></p> <p>Огноо: <i>[2019 оны 02 дугаар сарын 22-ний өдөр]</i></p> <p>Цаг: <i>[10 цаг 00 минут]</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>[Дорноговь Сайншианд, 2-р баг, Энхтайвны гудамж Чандмань-Илч ХХК-ийн удирдлагын байр</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>[3-р давхарт 307 тоот]</i></p> <p>Огноо <i>[2019 оны 02 дугаар сарын 22-ний өдөр]</i></p> <p>Цаг: <i>[10 цаг, 30 минут]</i></p> <p><i>Хаяг: tender.gov.mn /цахим хаягаар нээнэ./</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>[багц 1]</i></p>

Дөрөв: АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	<p>Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага MNS 13688:2000” Монгол улсын стандарттай дүйцэхүйц шаардлагыг хангасан байх.</p>	<p>Хувцасны материал нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажсан байна.</p> <p>Хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь хүнд саад болохгүй байх</p> <p>Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байх</p> <p>Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх</p>
2	<p>Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага</p>	<p>Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх</p> <p>Ус, тос, масло нэвтрүүлэхгүй байх</p> <p>Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй.</p> <p>Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.</p> <p>Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцолдохгүй байх</p>
3	<p>Ажлын тусгай хувцасны бүтэц, оруулга</p>	<p>Өвдөг тохой, өгзөгийн хэсгээр нэмэлт давхарлагаатай байна</p> <p>Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. Өмд өвдөг хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна.</p> <p>Гэрэлтдэг оруулгын өнгө саарал байна.</p> <p>Гэрэлтдэг оруулгын дээд талд ЧАНДМАНЬ-ИЛЧ гэсэн ширээстэй бичгийг бор өнгөөр хийх</p> <p>Үндсэн өнгө Инженер техникийн ажилтнуудынх цагаан саарал өнгөн дээр хар ногоон оруулгатай, ажилчдынх хөх өнгөн дээр цэнхэр оруулгатай, материал байна.</p> <p>Ажилчдын хувцасны ар талын нуруун дээр Чандмань-Илч гэсэн ширээсэн бичигтэй, зүүн талын энгэр дээр байгууллагын лого байна.</p> <p>Ажлын зуны тусгай хувцасыг өнгө дагуу товчтой хийнэ.</p> <p>Хэрэглэгч байгууллагын хүссэн загвараар хийж гүйцэтгэх</p>

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[2019 оны 02 дугаар сарын 22-ний өдөр]

(**ЧАНДМАНЬ-ИЛЧ ОНӨХХК**) -ын Захирал **Т.АЗБАЯР** танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Ажлын тусгай зориулалтын зуны хувцас							
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН АЖЛЫН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ЗУНЫ ХУВЦАС
НИЙЛҮҮЛЭГЧ

Хавсралт-1

<i>НЭР</i>	<i>РАЗМЕР</i>	<i>ТОО ШИРХЭГ</i>	<i>НЭГЖ ҮНЭ/НӨАТ/ тэй</i>	<i>НИЙТ ҮНЭ</i>
Хэмжээ өгөх		1		
ИТА	44	4		
ИТА	46	4		
ИТА	48	13		
ИТА	50	6		
ИТА	52	3		
ИТА	54	1		
Нийт тоо ширхэг				32

<i>НЭР</i>	<i>РАЗМЕР</i>	<i>ТОО ШИРХЭГ</i>	<i>НЭГЖ ҮНЭ</i>	<i>НИЙТ ҮНЭ</i>
Ажилтан	44	8		
Ажилтан	46	24		
Ажилтан	48	55		
Ажилтан	50	27		
Ажилтан	52	8		
Ажилтан	54	3		
Ажилтан	56	2		
Нийт тоо ширхэг				127

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн *[moo]*¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: *[moo]*
- Алдангийн нийт дүн: *[moo]*

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

**БАТЛАВ.
ЧАНДМАНЬ-ИЛЧ ХХК**

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

БАТЛАВ.

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Чандмань-Илч ХХК-ийн ажилтнуудын ажлын тусгай зориулалттай өвлийн хувцас нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалт /ХАЧИ-2019/04] гэрээ.

Дугаар № 10 *[Чандмань-Илч ХХК-ийн ажилтнуудын ажлын тусгай зориулалттай өвлийн хувцас нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалт /ХАЧИ-2019/04]*

Сайншанд хот

Нэг талаас ***[Чандмань-Илч ХХК]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ***[.....]*** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын __-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь ***[Чандмань-Илч ХХК-ийн ажилтнуудын ажлын тусгай зориулалттай зуны хувцас нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалт /ХАЧИ-2019/04]***

2. -г (цаашид “бараа” гэх) ***[.....төгрөг]*** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь “САЛАА ТӨМӨР ЗАМЫН АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ ” 2019 оны 01 дүгээр сарын 28 -ний өдрөөс өмнө нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь. Үйлчилгээ үзүүлсэн урирал бүр гэрээний дагуу олгоно..

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Ерөнхий инженер Б.Бат]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Энхтайваны гудамж 2-р баг]
[70522156]
[ХААН банк, 5360001473]

[.....]
[.....]
[.....]

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

